

БАТЛАВ. ШУТИС-ийн ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН

ДАРГА:

Н.ГАНЗОРИГ

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2022 ОНЫ БАГШ, АЖИЛЧДЫН СПОРТЫН НААДМЫН УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго

Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн боловсролыг дэмжих, Биеийн тамир спортын тухай хуулийг хэрэгжүүлэн багш, ажилчдын дунд биеийн тамир спортыг хөгжүүлэх, спортоор хичээллэх сонирхлыг өрнүүлэх, аварга баг тамирчдыг тодруулах зорилготой.

Хоёр. Тэмцээний төрөл, зохион байгуулах хугацаа

№	Төрлүүд	Хүний тоо			Хугацаа	Хариуцах эзэн	Явагдах байр
		Эр	Эм	Дас			
1	Шатар	Баг /5 хүнтэй/ Ганцаарчилсан			2022 оны 1-р сарын 09 нд 9 цагт	Ч.Навчаа	Номын сан
2	Сагсан бөмбөг	12	12	2	2022 оны 1-р сарын 06-8 нд	Б.Ганзориг	2-р байр, БУХС спорт заал
3	Ширээний теннис	Баг /5 хүнтэй/ Ганцаарчилсан			2022 оны 1-р сарын 9 нд 9 цагт	М.Амаржаргал	МХТС спорт заал
4	Ажлын байрны дасгал	5			2022 оны 1-р сарын 9 нд 9 цагт	Г.Ерөөлбат	1-р байр урлаг заал
5	Волейбол	12	12	2	2022 оны 1-р сарын 10-12 нд	М.Бат-Очир	2-р байр, БУХС спорт заал
6	Биллиард	Захирлын зөвлөл			2022 оны 1-р сарын 9 нд 11 цагт	О.Баатарзоригт Б.Бадам-Очир	Биллиард клуб

Гурав. Тэмцээний зохион байгуулалт

ШУТИС-ийн Нээлтэй боловсролын төв, ХШУС-ийн Биеийн тамир, спортын тэнхим хамтран зохион байгуулна. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудаас удирдамжийн дагуу төрөл тус бүрд баг, тамирчид оролцоно. Спортын тэмцээний нэгдсэн нээлтийн ажиллагаа 1-р сарын 06 ны 16⁰⁰ цагаас, хаалтын ажиллагаа волейболын тэмцээний сүүлийн өдөр болно. Нэгдсэн нээлтийн ажиллагаанд баг тамирчид сургуулийнхаа туг, хаягаа барин, жигд тоглолтын хувцастай оролцоно.

Дөрөв. Шагнал, урамшуулал

Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулж, нийлбэр дүнгээр 1, 2, 3-р байр эзлүүлж, цом, өргөмжлөл, дурсгалын медаль мөнгөн шагналаар шагнана. Сагсан бөмбөг, волейболын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 тамирчныг шилдэг тоглогчоор шалгаруулна. Багийн нийлбэр дүнд медалийн тоо, чанараар тооцон, өгсөх системээр дүгнэж байр эзлүүлнэ.

Үүнд:

- алтан медаль 25 оноо

- мөнгөн медаль 15 оноо
- хүрэл медаль 10 оноо
- 4-р байр 5 оноо

Жич: Ганцаарчилсан төрлийн амжилт багийн дүнд хамаарахгүй.

Тав. Оролцох багуудын эрхийн төлбөр

Сургууль тус бүр тэмцээний эрхийн төлбөр 1000000 төгрөгийг ШУТИС-ийн 1102928177 тоот дансанд тушаана.

Зургаа. Тэмцээн явагдах систем

- Багийн тооноос хамаарч техникийн зөвлөгөөн дээр тэмцээн явуулах системийг тохирно.
- Багууд нэр, дугаар бүхий дүрмийн дагуу тоглолтын өмсгөлтэй байна.
- Багууд 1 тоглолтын өмнө ирсэн байна.

Долоо. Багийн бүрэлдэхүүн

Тэмцээний төрлүүдэд бүрэлдэхүүн сургуулиудаас 2021 оны 01 тоот тушаалд нэр орсон үндсэн багш ажилтан, ажилчид байна. Гэрээт багш, ажилтан тэмцээнд оролцохгүй. Сургуулийн бус тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хожигдсонд тооцно.

Ажлын байрны дасгалын багийн тэмцээнд (*Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Шатарын тэмцээнд оролцож байгаа тамирчин оролцохгүй.*) тухайн сургуулийн санхүү-1, салбар тэнхимийн эрхлэгч 1, сургалтын алба 1, үйлчилгээний ажилтан 1, тэнхимийн туслах, сургалтын мастерын аль нэг-1 тус бүрээс бүрдсэн 5 хүнтэй баг байна.

Найм. Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөний хурал 2021 оны 12-р сарын 28-нд 10⁰⁰ цагаас *ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн өрөөнд /1-203/* болно. Техникийн зөвлөгөөнд бүрэлдэхүүн сургуулиудын Нээлтэй боловсролын төвийн төлөөлөл, багийн ахлагчийн хамт дараах материалыг бүрдүүлэн оролцоно. Үүнд:

1. Багийн баталгаажуулсан мэдүүлэг
2. 2021 оны 01 тоот тушаал, Сүүлийн 6 сар нийгмийн даатгал төлсөн байх.
3. 3-р тундаа хамрагдсан тамирчид оролцоно.
4. E-Mongolia бүх тамирчдыг шалгана. /Материалуудыг нээлтэй боловсролын төвөөс шалгаж баталгаажуулна./
5. Эрхийн төлбөр төлсөн баримт

Ес. Мэдүүлгийн заавар /А4 цаасан дээр хөндлөнгөөр бичнэ./

Батлав. ШУТИС-ийнСУРГУУЛИЙН ЗАХИРАЛ:.....

**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2022 ОНЫ СПОРТ НААДМЫН
.....ТӨРӨЛД ОРОЛЦОХ.....СУРГУУЛИЙН БАГИЙН МЭДҮҮЛЭГ**

эр/эм

Зураг	Хувийн дугаар	Овог нэр	Албан тушаал	Регистр	Биеийн өндөр	Биеийн жин	Цол зэрэг	Үүрэг

Багийн ахлагч:...../утас/.....

Багийн дасгалжуулагч:...../утас/.....

Тэмцээний ерөнхий шүүгч: БТСТэнхимийн багш



Г.Мөнхдорж